



ХААН БАНК

**ХААН БАНК ХК
2023 ОНЫ “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

1. Ерөнхий мэдээлэл

1.1. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс” болон Монголын Хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2022 оны А/58 дугаар тушаалын дагуу “Компанийн засаглалын кодексийг үнэлэх аргачлал”-ын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн “ХААН Банк” ХК-ийн засаглалын үнэлгээг танилцуулж байна. 2023 оны “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээгээр ХААН Банк ХК 88.9 оноо авч МХБ-ийн хувьцааны бүртгэлийн I ангиллын компаниудаас 7-р байр эзэлсэн.

1.2 “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-өөс томилогдсон эрх бүхий албан тушаалтан хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.

2. Үнэлгээний зорилго

2.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.

3. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээ нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6
4	Аудит, хяналтын тогтолцоо	6
5	Эрсдэлийн удирдлага	8
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6
7	Оролцогч талуудын эрх ашиг	8
8	Компанийн соёл	6
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10
Нэгдсэн дүн		72

4. Үнэлгээний аргачлал

4.1. Асуулга тус бүрийн хувьд хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж, хувьд шилжүүлэн үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно. Үүнд:

- Бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо;
- Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1 оноо;
- Үнэлгээ ирүүлээгүй бол 0 оноо.

4.2. Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

- Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;

- 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзнэ.

**ХААН БАНК ХК-ИЙН 2023 ОНЫ “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна

	Компанийн засаглалын зарчим	СЗХ-ноос ирүүлсэн үнэлгээ	Хэрэгжилт	Тайлбар
1	1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	1	Хэрэгжсэн	“ХААН Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам” нь хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 1 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан. Тус журмын 3 дугаар зүйлд ТУЗ-ийн үүрэг, хариуцлага, мөн 6.3 дугаар зүйлд ТУЗ-ийн даргын чиг үүрэг, хариуцлага, мөн 7.2 дугаар зүйлд ТУЗ-ийн нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагын талаар тус тус нарийвчлан зохицуулсан. "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 3.1.2-т зааснаар ТУЗ-ийн гишүүд нь Банкны урт хугацааны ашиг, сонирхолд чиглэн Банкны бүхий л үйл хэргийг удирдан чиглүүлэх, өөрийн үүргийг хэрэгжүүлэхдээ эрүүл саруул ухаанаар, хичээл зүтгэлтэйгээр оролцох, банкыг холбогдох хууль, дүрэм журмын дагуу ажиллах боломжоор хангах зэрэг үүрэг, хариуцлагыг Банканд хэрэгжүүлэх бөгөөд Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй. Журмын 6.3-т зааснаар ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн гишүүдийг томилогдоход чиглүүлэх сургалт, Компанийн засаглалын гэрчилгээ олгох хөтөлбөр, хэрэв шаардлагатай бол нэмэлт сургалтуудад хамруулах, ТУЗ-ийн гишүүний үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай бүх мэдээллийг ТУЗ-ийн гишүүд хүлээн авах, ТУЗ-ийн хэлэлцүүлэг болон аливаа шийдвэр гаргалтад хангалттай хугацаа гаргах, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг зохистой үйл ажиллагаагаар хангах, ТУЗ-ийн гишүүд, хараат бус гишүүд мөн Гүйцэтгэх захирал болон дээд түвшиний удирдлагын ажлын үзүүлэлт, гүйцэтгэлийг жил тутам үнэлэх, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын баг хоорондын зохистой харилцааг хангах зэрэг үйл ажиллагаагаар ханган ажиллана. Мөн түүнчлэн ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийг үүрэг, хариуцлагаа хангалттай биелүүлэхэд, ТУЗ-ийн хурлын хэлэлцэх асуудлыг тогтоон, тухайн хурлыг даргалан хуралдуулахаас гадна хурлын тэмдэглэлийг хадгалах боломжоор хангах, ТУЗ-өөс томилсон хөндлөнгийн зөвлөлтэй хамтран ажиллах, ТУЗ-ийн гишүүдийн ажлын үзүүлэлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, ТУЗ-ийн гишүүдийн дотоод

				<p>маргаан, ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэж үүний үр дүнд тус гишүүдийг үүрэгт ажлаас чөлөөлөх боломж гаргах зэрэг үндсэн үүрэг, хариуцлагатай. Мөн Журмын 7.2-т заасны дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийг зөв үйл ажиллагаа явуулж байгаа болон хууль, дүрэм, журам мөн Банкны дотоод журмуудын дагуу үүргээ хэрэгжүүлж байгаад анхаарал хандуулна. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн даргад ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулахад (үүнд мэдээлэл өгөх, хэлэлцэх асуудал бэлдэх, хурлын тайлагнал, үнэлгээ болон сургалтын хөтөлбөр) туслана.</p>
2	<p><i>1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.</i></p>	2	Хэрэгжсэн	<p>ТУЗ-ийн ердийн гишүүдийн хувьд: ХААН Банкны ТУЗ-ийн дэргэдэх Компанийн засаглалын хорооны ТУЗ-ийн 2021 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 15 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Компанийн засаглалын хорооны дүрэм”-ийн 2.1.1.4-т “ТУЗ-д нэр дэвшигчдэд тавигдах шалгуур, үүн дотор боловсрол, ажлын туршлага зэргийг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдийн санал болгосон нэр дэвшигчдэд үнэлгээ хийх, шалгуурыг тогтоох” чиг үүргийн хүрээнд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдээс санал болгосон нэр дэвшигчдэд үнэлгээ хийсний үр дүнд хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлдэг.</p> <p>ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хувьд: Банкны хувьд ТУЗ-ийн хараат бус гишүүдийг томилохдоо Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ыг удирдлага болгон баримталдагаас гадна холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэдэг. ХААН Банк нь дээрх хууль тогтоомж, журмыг баримтлан (2023 оны хувьд: ХААН Банкны ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 17 тоот тогтоолоор) ТУЗ-ийн хараат бус гишүүнд сонгон шалгаруулалт зохион байгуулах, нэр дэвшигчийг шалгаруулах, хувьцаа эзэмшигчийн хуралд нэр дэвшүүлэх чиг үүрэг бүхий “ТУЗ-ийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх түр хороо”-г байгуулж ажилладаг бөгөөд Банкны “Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн нэр дэвшүүлэх журам”-ыг баримтлан ажилладаг. Энэхүү "Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн нэр дэвшүүлэх журам"-ын 1.1-т заасны дагуу тус журмаар ХААН Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах бөгөөд нийт нэр дэвшигчдээс хууль, журамд заасан шаардлага, шалгуурыг хамгийн сайн</p>

				<p>хангаж байгаа нэр дэвшигчийг хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлж ажилладаг.</p> <p>Банк нь ТУЗ-ийн гишүүдийн хууль, журамд заасан шаардлага, шалгуурыг хангаж байгаа талаарх мэдээллийг МБ-нд жил бүр өгч ажилладаг. Мөн ТУЗ-ийн дэргэдэх Компанийн засаглалын хороо нь өөрийн Дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн жил тутмын ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хяналт тавих, ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт, бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнтэй байдалд жил тутам үнэлгээ хийдэг болно.</p>
3	<p><i>1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршилага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.</i></p>	1	Хэрэгжсэн	<p>2022 оны үйл ажиллагааны тайланд тусгаж, вэб сайт дээр байршуулсан.</p> <p>Хөрөнгө оруулалт – Тайлан үзүүлэлт – Үйл ажиллагааны тайлан /https://www.khanbank.com/personal/about/pdfviewers/detail/5757/?type=165&slug=annual-report /</p>
4	<p><i>1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага болон хүйсийн</i></p>	1	Хэрэгжсэн	<p>ХААН Банкны ТУЗ нь Компанийн тухай хууль, ХААН Банкны Дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу үйл ажиллагаа явуулдаг. Мөн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн Хороо, Аудитын Хороо, Хүний Нөөцийн Хороо болон Компанийн Засаглалын Хороо нь тус тусын дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулдаг.</p> <p>ХААН Банк нь Компанийн Засаглалын Кодекс /ТУЗ-ийн 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн №25/1 тоот тогтоол/-гоо ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлага нь Монголбанкны холбогдох журмын дагуу байна гэж заасан. Мөн тус Кодекс-т ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн үндсэн чиг үүргийг зааж өгсөн. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүрт нэг хараат бус гишүүн байхаар Банкны Дүрэмд заасан. Мөн СЗХ-ны Компанийн засаглалын кодекс заасны дагуу</p>

	<i>тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.</i>			хүйсийн тэнцвэртэй байдлыг ТУЗ-өөр зогсохгүй, компанийн гүйцэтгэх удирдлага, ажилтнуудын түвшинд ч хадгалахыг эрмэлзэх зохицуулалтуудыг холбогдох дотоод баримт бичигт тусгагдсан байдаг.
5	<i>1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	2	Хэрэгжсэн	"ХААН Банкны Компанийн засаглалын кодексын 12. ТУЗ-ийн Байнгын Боловсрол: 12.1. Банк нь ТУЗ-ийн шинэ гишүүдэд өөрсдийн үүргээ биелүүлэхэд нь туслах үүднээс тус Банк, түүний бизнес үйл ажиллагаа болон бусад сэдвээр чиг баримжаа олгох сургалтын хөтөлбөр санал болгодог. Үүнээс гадна ТУЗ-ийн гишүүн бүр, мөн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтанд хамрагдана. Банк ТУЗ-ийн гишүүдэд мэргэжлийн боловсрол олгох байнгын үйл ажиллагааны хүрээнд сургалтын хөтөлбөрүүдэд хамрагдах боломж олгоно. ТУЗ нь бүх гишүүдэд болон тодорхой гишүүдэд ямар сургалт авах шаардлагатай байгааг жил бүр тогтоож, өөрийн төсөв дээр үндэслэн тухайн жилд авах сургалтуудыг шийдвэрлэнэ" гэж заасан. ХААН Банкны ТУЗ-ийн хувьд, 2023 оны 1 дүгээр улирлын хувьд, ТУЗ-ийн гишүүдэд зориулан Компанийн засаглал, удирдлагын менежмент сэдэвт хэлэлцүүлэг, сургалтыг Вестлэйк Говернанс Лимитед /Westlake Governance Limited/ компани 2023 оны 03 сарын 23-30-ны өдөр зохион байгуулсан. ТУЗ-д анх сонгогдоно томилогдож буй гишүүдэд ТУЗ-ийн дэргэдэх Компанийн Засаглалын Хорооноос ТУЗ-ийн шинэ гишүүдэд чиг баримжаа олгох, шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн гишүүдэд мэргэжлийн, хувь хүний болон онлайн сургалтуудыг Банкны холбогдох удирдлагуудтай хамтран ажиллах замаар зохион байгуулах тасралтгүй сургалтын хөтөлбөрийг бий болгох явцыг хянах, мониторинг хийх чиг үүрэгтэй ажилладаг. (Хорооны Дүрмийн 2.1.3.2 дахь заалт)
6	<i>1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	2	Хэрэгжсэн	ХААН Банкны 2023 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан ХААН Банкны Дүрмийн 10.1 дэх хэсэгт "ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно" гэж, 10.3 дахь хэсэгт "ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүргийг түүнтэй байгуулах гэрээнд тусгана. ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай байгуулах гэрээний нөхцлийг ТУЗ баталгаажуулах ба ТУЗ-ийг төлөөлж, ТУЗ-ийн дарга гэрээнд гарын үсэг зурна" гэж тус тус тусгасан болно. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын хүлээх эрх, үүргийн талаарх зохицуулалт нь Банкны Дүрэм, Компанийн Засаглалын кодекс, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон холбогдох хөдөлмөрийн гэрээнд тодорхой нарийвчлан туссан байдаг.

ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ

Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ

7	<i>2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	1	Хэрэгжсэн	ХААН Банкны ТУЗ нь нийт 9 гишүүнээс бүрдэх бөгөөд үүнээс 3 нь хараат бус гишүүн байна. (ХААН Банкны Дүрмийн 9.1 заалтын дагуу). 2021 оны 11 дүгээр сарын 10-ний өдрийн ТУЗ-ийн №28 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар хараат бус гишүүн Т.Дарьбумыг сонгон ажиллаж байгаа. ТУЗ-ийн дэргэдэх хороодыг ТУЗ-ийн хараат бус гишүүд даргалж ажилладаг.
8	<i>2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	2	Хэрэгжсэн	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооны дүрэм нь 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооны даргаар хараат бус гишүүн А.Тамир ажилладаг. Аудитын хорооны Дүрэмд заасны дагуу тус хорооны үндсэн чиг үүргүүдээс дурьдвал: 1. Дотоод аудитын чиг үүрэг болон Ерөнхий Аудиторын бие даасан байдлыг хангах, 2. Банкны санхүүгийн тайлан гаргах үйл явцад хяналт тавих, 3. ТУЗ-тэй байгуулсан гэрээний дагуу үзүүлж буй гадны аудитын үйлчилгээнд хяналт тавих гэх зэрэг болно.
9	<i>2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны</i>	2	Хэрэгжсэн	ТУЗ-ийн дэргэдэх Компанийн засаглалын Хороо нь өөрийн Дүрмийн 2.1.2-т заасны дагуу ТУЗ-ийн удирдлагын бус гишүүд (үүн дотор ТУЗ-ийн хороодын гишүүд)-ийн цалин олговрын хүртээмжтэй байдлын талаар жилд нэгээс доошгүй удаа хяналт тавьж, ТУЗ-д санал зөвлөмж өгөх чиг үүрэгтэй ажилладаг. Тус хороог ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Дарьбум даргалдаг бөгөөд ТУЗ-ийн цалин урамшууллын асуудлыг ТУЗ-ийн санал болгосоор хувьцаа эзэмшигчдийн хурал батладаг болно.

	<i>дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>			
10	<i>2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</i>	2	Хэрэгжсэн	<p>ТУЗ ийн ердийн гишүүдийн хувьд: ХААН Банкны ТУЗ-ийн дэргэдэх Компанийн засаглалын хорооны ТУЗ-ийн 2021 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 15 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Компанийн засаглалын хорооны дүрэм”-ийн 2.1.1.4-т “ТУЗ-д нэр дэвшигчдэд тавигдах шалгуур, үүн дотор боловсрол, ажлын туршлага зэргийг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдийн санал болгосон нэр дэвшигчдэд үнэлгээ хийх, шалгуурыг тогтоох” чиг үүргийн хүрээнд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдээс санал болгосон нэр дэвшигчдэд үнэлгээ хийсний үр дүнд хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлдэг.</p> <p>ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хувьд: Банкны хувьд ТУЗ-ийн хараат бус гишүүдийг томилохдоо Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ыг удирдлага болгон баримталдагаас гадна холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэдэг. ТУЗ-ийн хараат бус гишүүнд сонгон шалгаруулалт зохион байгуулах, нэр дэвшигчийг шалгаруулах, хувьцаа эзэмшигчийн хуралд нэр дэвшүүлэх чиг үүрэг бүхий "ТУЗ-ийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх түр хороо"-г байгуулж ажилладаг.</p>
11	<i>2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл</i>	2	Хэрэгжсэн	<p>ХААН Банкны ТУЗ нь дэргэдээ Эрсдэлийн Хороо, Аудитын Хороо, Хүний Нөөцийн Хороо, Компанийн Засаглалын Хороо гэсэн байнгын хороод болон Нэр Дэвшүүлэх түр хороог шаардлагатай үед нь ТУЗ-ийн шийдвэрээр байгуулж ажилладаг. Эдгээр хороод нь үйл ажиллагааны дүрэм, журамтай бөгөөд ТУЗ-ийн гишүүд мэдлэг, ур чадвар, ажлын туршлагыг харгалзан хороодын бүрэлдэхүүнд орж ажилладаг.</p>

	<i>ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</i>			
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ				
Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн байдлыг хангана.				
12	<i>3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	1	Хэрэгжиж буй	ХААН Банкны үнэт цаас гаргах үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн хуулийн дүгнэлтийг боловсруулсан Өмгөөллийн “Хаан Лекс Партнерс” хуулийн фирм нь Банкны хувьцаат компани болохтой холбогдуулан шинэчлэн батлагдах дотоод дүрэм, журмыг боловсруулан Үнэт цаасны танилцуулгад хавсаргасан болно. Иймд “ХААН Банкны мэдээллийн ил тод байдал, мэдээллийг толилуулах бодлого”-ын төслийг ТУЗ-ийн гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд дээрх бодлогыг батлуулахаар хүлээгдэж байгаа.
13	<i>3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i>	2	Хэрэгжсэн	Банкны засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэж ажилладаг. Банкны цахим хуудасны Хөрөнгө оруулалт, Тогтвортой хөгжил цэсүүдэд Банкны жилийн үйл ажиллагааны тайлан, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн тайлан, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан гэх зэрэг баримт бичиг тайлан мэдээллүүдийг хуульд заасан хугацаанд ил тод тайлагнаж явдаг.
14	<i>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс,</i>	2	Хэрэгжсэн	ХААН Банк нь 2019 оноос жил бүр Тогтвортой хөгжлийн тайлангаа бэлтгэн олон нийтэд ил тод хүргэдэг болсон. Уг тайлан нь ХААН Банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Тогтвортой санхүүжилт, Тогтвортой үйл ажиллагаа, Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт, Тогтвортой хамтын ажиллагаа ба тайлагнал гэсэн 4 чиглэлд хийж хэрэгжүүлсэн санал санаачлагууд, тоон мэдээлэл болон холбоотой баримт бичгүүдийн тухай мэдээллийг багтаадаг. Мөн тайланд Банкны Тогтвортой хөгжлийн бүтэц, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын зүгээс энэ чиглэлд тавьж буй зорилго зорилтын тухай мэдээллийг багтаадаг. Тогтвортой хөгжлийн, БОНЗ-ын тайланг Банк өөрийн вэб сайтаар дамжуулан олон нийтэд мэдэгддэг.

эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана

15	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	2	Хэрэгжсэн	ХААН Банкны ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүрэмд хөндлөнгийн аудитортой харьцах харилцааны талаар тусгасан байдаг. Аудитын хороо нь тус Банкны санхүүгийн тайланд хараат бус аудитыг хийх компанийг баталгаажуулж, ТУЗ нь сонгодог.
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	2	Хэрэгжсэн	ХААН Банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал тус бүр тухайн жил хөндлөнгийн аудитын байгууллагын удирдлагын төлөөлөлүүд хуралд оролцож тухайн жилийн аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулж, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг. Мөн ТУЗ-ийн хурал болон ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хуралд оролцдог болно.
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар	2	Хэрэгжсэн	ХААН Банкны ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд Дотоод Аудит нь харьяалагддаг. ДА-ын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг ХААН Банкны жилийн санхүүгийн аудитын тайланд зохих мэдээллийг тусгаж, Банкны цахим хуудсаар олон нийтэд мэдээлж ажилладаг.

	дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.			
ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина				
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	2	Хэрэгжсэн	ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо нь Банкны Дүрэм болон Эрсдэлийн хорооны дүрэмд заасан чиг үүргийн дагуу Банкны эрсдэлийн ерөнхий түвшинд нийцсэн эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавих, банкны эрсдэлийн удирдлагын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлон, үнэлэлт, дүгнэлт гаргах, ТУЗ-өөс тогтоосон хүлээн зөвшөөрөх эрсдэл болон эрсдэлийн лимитийн хэрэгжилтийг баталгаажуулах замаар ТУЗ-д банкны эрсдэлийн түвшинг хянахад дэмжлэг үзүүлэн ажилладаг. ТУЗ нь Банкны эрсдэлийн хяналт, мониторингийн үйл ажиллагаатай холбоотой бодлого журмыг хянан баталдаг.
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны	2	Хэрэгжсэн	<p>ТУЗ-ийн хараат бус гишүүн ноён Ханс Аарт Йонгеянс нь 2020 оны 8 дугаар сараас эхлэн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хорооны даргаар тасралтгүй ажиллаж байна. 2022 оны 10 дугаар сарын ТУЗ-ийн хурлын шийдвэрээр Эрсдэлийн хорооны гишүүдийн тоог шинэчлэн баталж, нийт дөрвөн гишүүнтэйгээр хуралдаж байна.</p> <p>ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хорооны үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүний талаарх мэдээллийг банк жил бүрийн тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэн ажилладаг. Мөн хорооны ирц, хуралдсан асуудал, гаргасан шийдвэр, давтамжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Эрсдэлийн хорооны даргын хараат бус гишүүний ажлын тайланд улирал бүр тусган, банкны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж байна.</p>

	<i>хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>			
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>	2	Хэрэгжсэн	БОНЗ-ын эрсдэлээр хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн Moody's rating оноо 43 авсан. Тогтвортой хөгжлийн тайланд энэ мэдээллүүд тусгагдсан. Үүнээс гадна: Банк нь өөрийн санхүүжүүлж буй бизнесүүдийн БОНЗ Эрсдэлийг үнэлж, хянаж ажилладаг процесстой. Энэ үйл ажиллагаа Банкны ЗҮАЖурмын дагуу зохицуулагддаг. Мөн холбогдох шалгууруудыг хангасан тохиолдолд Ногоон зээл олгодог. Банкны төв оффис болох ХААН Цамхаг нь Ногоон оффис гэрчилгээ авч байгаа юм.
21	<i>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.</i>	2	Хэрэгжсэн	ХААН Банкны Комплаенсийн газар нь Банкны үйл ажиллагааны комплаенсийн хяналтыг бүрэн хариуцаж мөн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа ТУЗ-д болон ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороонд сар бүр тайлагнаж явдаг.
ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ				
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна				
22	<i>6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	2	Хүлээгдэж буй	ТУЗ-ийн дэргэдэх Компанийн засаглалын Хороо нь өөрийн Дүрмийн 2.1.2-т заасны дагуу ТУЗ-ийн удирдлагын бус гишүүд (үүн дотор ТУЗ-ийн хороодын гишүүд)-ийн цалин олговрын хүртээмжтэй байдлын талаар жилд нэгээс доошгүй удаа хяналт тавьж, ТУЗ-д санал зөвлөмж өгөх чиг үүрэгтэй ажилладаг. ТУЗ-ийн цалин урамшууллын асуудлыг ТУЗ-ийн санал болгосоор хувьцаа эзэмшигчдийн хурлаар ил тод хэлэлцэж батладаг болно.
23	<i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон</i>	2	Хэрэгжсэн	Банк нь Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2011 оны 12 дугаар сарын 26-ны 445 тоот тушаалаар батлагдсан “ХААН Банкны Хүний Нөөцийн Бодлого”, Гүйцэтгэх захирлын орлогчийн 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 02/205

	<i>ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.</i>			тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “ХААН Банкны ажилтны гүйцэтгэлийн удирдлагын тухай журам”-аар ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг дэлгэрэнгүй, тодорхой зааж өгсөн байдаг.
24	<i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>	1	Хүлээгдэж буй	СЗХ-ны Компанийн засаглалын кодексийн үйлчлэх хүрээ нь Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаас гаргагч, даатгагч, итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компани дагаж мөрдөхөөр зохицуулсан байдаг. 2022 оны байдлаар ХААН Банк нь ХХК хэлбэртэй байсан тул энэ мэдээлэл нь жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүй тусгагдаагүй байдаг хэдий ч ХААН Банкны жил бүрийн үйл ажиллагааны тайлан нь өөрийн цахим хуудсанд нийтэд нээлттэй байдаг.
ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ				
25	<i>7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>	1	Хэрэгжсэн	ХААН Банк нь оролцогч талуудын эрх ашгийг ханган ажиллах тал дээр анхааран ажиллаж байна. ХААН Банкны "алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс"-т харилцагчид болон бусад оролцогч талуудтай хамт эгнэгт өсөн дэвшинэ гэж тодорхойлсон байдагаас гадна ТУЗ-өөс батлагдсан Ёс зүйн дүрэмд энэ талаар тусгаж зохицуулсан байдаг болно.
26	<i>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа</i>	2	Хэрэгжсэн	ХААН Банкны жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан ажиллахаа тодорхойлсон байдагаас гадна 2015 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот

	<i>ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>			тогтоолоор баталсан "ХААН Банкны ёс зүйн дүрэм"-д энэ талаар шат шатны удирдлагууд, Банкны ажилтнуудын түвшинд нарийвчлан заасан байдаг.
27	<i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>	2	Хэрэгжсэн	ХААН Банкны үйл ажиллагааны жилийн тайлан, тогтвортой хөгжлийн тайлан, санхүүгийн тайлан, хөндлөнгийн үнэлгээний тайлан зэргийг Банкны цахим хуудсанд тогтмол хөтлөн нийтэлж, оролцогч талууд буюу олон нийтийг мэдээллээр хангаж ажилладаг.
28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	2	Хэрэгжсэн	ХААН Банкны ажилтны гомдол шийдвэрлэх үйл ажиллагааны журмыг Гүйцэтгэх Захирлын 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 01/194 тоот тушаалаар батласан. 2012 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн Гүйцэтгэх Захирлын №09 тоот тушаалаар "Шүгэл үлээх бодлого"-ыг батласан. Ажилтны мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг ХААН Банк Академи эрхлэн хариуцдаг. Ажилтны нийгмийн асуудал дээр заавар, санамжийн дагуу ажилтны ар гэрийн гачигдал зэрэгт нь мөнгөн тусламж өгдөг. Ажилтнуудын нийгмийн хөгжилд зориулж нийгмийн хөгжлийн тусгай санхүүжилт олгодог бөгөөд энэ нь Хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан.
НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ				
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно				
29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд</i>	2	Хэрэгжсэн	ХААН Банкны ТУЗ нь 2015 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоолоор баталсан "ХААН Банкны ёс зүйн дүрэм"-д энэ талаар шат шатны удирдлагууд, Банкны ажилтнуудын түвшинд нарийвчлан заасан байдаг. Тус тогтоолд заасны дагуу Банкны гүйцэтгэх захирал энэхүү Дүрмийг хэрэгжүүлэлтэнд хяналт мониторинг тавьж ажилладаг. Энэ талаарх холбогдох баримт бичгүүд болон мэдээллүүдийг тогтмол хөтлөн олон нийтэд ил тод байдаг.

	<i>мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>			
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i>	2	Хэрэгжсэн	ХААН Банк нь анх 2012 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн Гүйцэтгэх Захирлын №09 тоот тушаалаар "Шүгэл үлээх бодлого"-ыг батлан мөрдөн ажиллаж байна. Банкны Дотоод аудитын газар нь тус бодлогын Дотоод аудитын үйл ажиллагааны дүрэмд зохицуулж ажилладаг.
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>	2	Хэрэгжсэн	Энэ тухай зохицуулалтууд нь Банкны дотоод баримт бичгүүдээр зохицуулагдаж, Банкны холбогдох газар нэгжүүд хяналтыг хэрэгжүүлж ажилладаг. ХААН Банкны ТУЗ нь 2015 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоолоор баталсан “ХААН Банкны ёс зүйн дүрэм”, 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 14 тоот тогтоолоор баталсан “ХААН Банкны авлига, хээл хахуулийн эсрэг бодлого” мөн өдрийн ТУЗ-ийн 12 тоот тогтоолоор “Улс төрд нөлөө бүхий этгээдийн бодлого” зэргийг батлан мөрдөн ажилладаг болно. Энэ тухай мэдээлэл нь Банкны цахим хуудсанд байршиж олон нийтэд нээлттэй байдаг.
ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ				
Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана				
32	<i>9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.</i>	2	Хэрэгжсэн	Компанийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчтай тогтмол харилцах цахим сувгийг хөгжүүлсэн бөгөөд investor_relations@khanbank.com имэйл хаяг, ХААН Банкны цахим хуудасны “Хөрөнгө оруулагчид” гэсэн буланг хөгжүүлэн мэдээлэл хүргэн ажиллаж байна. Хөрөнгийн биржийн цахим хуудсаар хөрөнгө оруулагчдад өгөх мэдээллийг давхар мэдээлж байна (https://mse.mn/mn/company/563)

33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	1	Хэрэгжсэн	
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	2		<p>ХААН Банкны Компанийн засаглалын кодексийн 3.1.1-т ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн тухай Монголбанкны журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг зохих ёсоор хөтлөх, тогтмол шинэчлэх үүрэг хүлээнэ гэж заасан. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүн дотор саналын эрх, ногдол ашиг авах эрх болон бусад эрхийг ХААН Банкны Дүрмийн 6 дугаар зүйлд тодорхой зааж өгсөн бөгөөд үүнд тус Банкны хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хуулиар олгогдсон бүх эрхийг эдлэхээс гадна хувьцаа шилжүүлэх, эзэмшихтэй холбоотой тодорхой эрхүүдийг эдлэхээр зааж өгсөн байна. Хувьцаа эзэмшигчдийн саналын эрх нь эзэмшиж буй хувьцааны тоотой тэнцүү байх ба саналын эрхээ хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж буй асуудлаар санал өгөх замаар эдлэнэ. Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах талаар тус Банкны Дүрэм, Компанийн засаглалын кодекс болон холбогдогч зохицуулагч байгууллагууд болох СЗХ Монголбанк МХБ-ийн холбогдох журамд заасан арга хэмжээнүүдийг авдаг.</p>
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	2		<p>Банкны Дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрх, үүрэг, хувьцаа эзэмшигчийн эдлэх эрх, хүлээх үүргийн талаар Монгол улсын холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагуудын журам, дүрэмд нийцүүлэн дэлгэрэнгүйгээр тусгаж өгсөн байдаг тул хувьцаа эзэмшигчид хууль тогтоомжийн хүрээнд бүхий л эрх, үүргээ хэрэгжүүлэх боломжоор хангасан байдаг.</p>
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх	2		<p>ХААН Банкны ТУЗ нь 2017 онд “Ашиг сонирхлын Зөрчлийн Бодлого”, “Нэгдмэл Сонирхолтой Этгээдийн Хэлцлийн Бодлого”-ыг тус тус батласан байдаг бөгөөд Банкны удирдлага болон шат шатны нэгжүүд үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг. Мөн Компанийн Дүрэмд их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй</p>

	<p><i>зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</i></p>			<p>хэлцлийн зохицуулалтын талаар тусгайлсан хоёр бүлэг болгон нарийвчлан оруулсан байдаг. Түүнчлэн зохицуулагч байгууллагын хувьд Монголбанканд сар бүр санхүүгийн тайлан тооцоо, холбогдох этгээдэд олгосон хэлцлийн талаар тайлагнадаг бөгөөд энэ талаарх мэдээ, тайлан нь Банкны цахим хуудсанд хөтлөж ажилладаг.</p>
--	---	--	--	--